

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/10

Арвайхээр

Тооллогын комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 72 дугаар зүйлийн 72.1, 72.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын 2019 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн үзлэг, тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Т.Эрдэнэсүрэн (Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд: А.Баяндүүрэн (Орон нутгийн өмчийн газрын хууль эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн програм хариуцсан мэргэжилтэн)

Б.Пүрэвсүрэн (Орон нутгийн өмчийн газрын бараа, зөвлөх үйлчилгээ, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Эд хөрөнгийн тооллогыг 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 28-ны өдрүүдэд заавар журмын дагуу чанартай хийж гүйцэтгэн, тооцоог бодож, үр дүнг танилцуулахыг тооллогын комиссын дарга (Т.Эрдэнэсүрэн), Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн (Б.Дэлгэрмаа) нарт даалгасугай.

ДАРГА



Н.ГАНБОЛД

177110010